



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/41

Номгон

“Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2023 оны үйл ажиллагааны санхүүжилтийг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XII дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/55 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 1.1.7 дахь заалтад тусгагдсан “Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2023 оны үйл ажиллагааны санхүүжилт болох 100.000.000 (Нэг зуун сая) төгрөгийг олгосугай.

2.Үйл ажиллагааны санхүүжилт 100.000.000 (Нэг зуун сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Санхүүжилтийг хуулийн хүрээнд үр ашигтай зарцуулж, хяналт тавьж ажиллахыг “Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв”-ийн дарга (Т.Пунцагдаш)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310105

D:\2023 он\захирамж-2023\Захирамж-2023 он.docx